



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/192

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ын 1.2, 1.4 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2023 оны А/32 дугаар тушаалын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад Мал эмнэлэг, үржлийн алба үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой тэмдэглэх арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажлын хэсгийн ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ой тэмдэглэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, бүтээлч ажлын төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх, ажлын явц үр дүнг тооцож ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА




А.ИШДОРЖ

6223 11 0352

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр
сарын 04-ны өдрийн 119 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт



**МАЛ ҮРЖЛИЙН АЛБА ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 100 ЖИЛИЙН
ОЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

С.Цэдэнбалжир (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Ч.Гүнсэнхорол (аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн
дарга)

Ө.Жамдүдсансүм (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Биеийн тамир спортын газрын дарга)

Д.Өсөх-Эрдэнэ (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын
хүрээний агентлаг Соёл урлагийн газрын дарга)

Д.Түмэнжаргал (аймгийн Хөгжимт драмын театрын дарга)

Н.Дулам (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн
бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах
мэргэжилтэн)

Э.Ёндонсамбуу (аймгийн Мал зүйч үржүүлэгчдийн холбооны
тэргүүн Монгол улсын зөвлөх Мал зүйч) (зөвшилцсөнөөр)

Н.Дашжамц (Монгол улсын зөвлөх Мал зүйч)

Д.Дүгэрсүрэн (Монгол улсын зөвлөх Мал зүйч)

Нарийн бичгийн дарга: Б.Цэнгэл (Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг
Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга
Монгол улсын Тэргүүлэх Мал зүйч)

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр
сарын 04-ны өдрийн 01 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



АЖЛЫН УДИРДАМЖ

Удирдамжийн зорилго:

Монгол Улсад үржлийн алба үүсэн байгуулагдаж, өндөр ашиг шимт баталгаажсан үүлдэр омгийн мал бий болгох, шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэн зохиомол хээлтүүлэг, хөврөл үр шилжүүлэн суулгах зэргээр нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэн, малын чанарыг сайжруулан малчдын орлогыг нэмэгдүүлэх ажлыг явуулж ирсэн түүхт ойг угтсан бүтээлч ажлын төлөвлөгөө гаргах, цаашид мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлж, бүтээмж, үр ашиг, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний зах зээлийн үнэлэмжийг байнга нэмэгдүүлэх чиглэлээр шийдэл гаргах, мал аж ахуйн салбарт ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа мэргэжилтнүүд, малчид, ажилтан ажиллагсдыг шагнаж урамшуулахад оршино.

Хамрах хүрээ:

Мал үржлийн ажил үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд, лаборатори, хувийн хэвшлүүд, малчид

Хэрэгжүүлэх ажлын чиглэл:

1. Мал үржлийн чиглэлээр хэрэгжүүлэх ойг угтсан бүтээлч ажлын төлөвлөгөөг боловсруулан батлах

2. Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулж, ажлын чиглэл, хамрах хүрээ, үр дүнгийн талаар тайланг танилцуулж санал солилцох

3. Төлөвлөгөөт ажлыг хугацаанд нь зохион байгуулж, тайлагнах

Гарах үр дүн:

Мал үржлийн салбарт тодорхой ажил хийгдэж, үр дүн гарсан байна.